



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 07/00-00/001-03

Улаанбаатар хот

Барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам
стандартыг мөрдөж ажиллах тухай

Улсын хэмжээнд бүтээн байгуулалтын ажлууд эхэлж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил олгогч та бүхэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах, хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа дээшлүүлэх, барилгын үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, өргөх, зөөх машин механизмын аюулгүй ажиллагааг хангуулах, аливаа осол гэмтэлд хүргэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл, мэдээллийн систем /om.inspection.gov.mn/-д 2019-2023 онд барилгын салбарт 180 осол бүртгэгдэж, үүнээс 47 хүн нас барсан, 88 хүн хүнд, 45 хүн хөнгөн гэмтсэн тохиолдол бүртгэгдсэн байна.

Иймд барилга угсралтын болон барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил олгогч нарт дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг ДААЛГАЖ байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж, үйл ажиллагааг төлөвлөх;

3. Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах;

4. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн /бригад/, иргэд хоорондын гэрээгээр ажилладаг ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн гэрээ болон бусад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх үүргийг тодорхой тусгаж хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах;

5. “Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм” /БНБД 12-03-04/-ийн 6.1.1 /барилгын талбайн ажлын байр нь үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрэн хангахад зориулагдан бэлтгэгдсэн байх ёстой/-д заасны дагуу үйлдвэрлэлийн аюултай хүчин нөлөөлөлд өртөж болох өндөрт ажиллах ажлын байрны /шат, вандан, хаалт, хамгаалалт/ аюулгүй байдал болон “UCS0001-012019 Орчны аюулгүй байдал стандарт” Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлагын 5, 6, 7, 8, 9, 11-д тус тус заасан барилгын түр хашаа, хашлага, хамгаалалтын хүрээ, нийтийн эзэмшлийн зам, талбайн хамгаалалтын байгууламж, тэмдэг, тэмдэглэгээг тогтоосон хэмжээгээр байршуулан ажиллах;

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт зохион байгуулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан ажилтнуудыг сургалтад хамруулах, шалгалт өгсөн ажилтнуудыг ажиллуулах;

7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчилга аваагүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;

8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг байгуулах, осолд дөхсөн тохиолдол бүрийг судалж, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч үйлдвэрлэлийн талбайд гарч болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлж ажиллах;

9. “Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм” /БНБД 12-03-04/-ийн 6.4.2.Үйлдвэрлэлийн талбайд цахилгааны байнгын ба түр сүлжээний техникийн үйлчилгээг, цахилгааны аюулгүй ажиллагааны зохих мэргэжлийн зэрэг бүхий цахилгаан техникийн ажилтнуудаар гүйцэтгэвэл зохино/-т заасныг баримтлан цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаа эсэх, цахилгааны түр щит, гал хамгаалагчийн бүрэн бүтэн байдал, цоожлох пайзлах журам баталж мөрдүүлэх;

10. Өргөх, зөөх, тээвэрлэх механизм, цахилгааны болон даралтат сав шугам хоолойд тавигдах шаардлагыг хангаагүйн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд шууд, шууд бусаар хор хохирол учруулж болзошгүй тохиолдолд үйл ажиллагааг шууд зогсоон, эвдрэл гэмтлийг арилгуулсны дараа үргэлжлүүлэх;

11. Ажилтнуудыг ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, зохистой хэрэглээнд хяналт тавих;

12. “Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм” /БНБД 12-03-04/-ийн 6.6.1, 6.6.3 - 6.6.8-д тус тус зааснаар барилга угсралтын ажил гүйцэтгэх үед үүсэж болох хортой хүчин зүйлийг арилгах талаар дотоод хяналт тавих, хорт хий ялгарсан нөхцөлд тухайн байранд ажил гүйцэтгэхийг зогсоох арга хэмжээ авч, ажлын байранд агаар сэлгэлтийн системд хяналт тавих;

13. Үйлдвэрлэлийн хүнд ба хортой хүчин зүйлсийн үйлчлэлд ажиллаж байгаа ажилтнуудыг Эрүүл мэндийн сайдын баталсан журмын дагуу урьдчилсан үзлэгт заавал, ажилд орсны дараа эмнэлгийн хугацаат үзлэгт тухай бүр хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж хэвших;

14. Үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсгийг тохижуулахдаа ажилтнуудын тогтмол буюу түр байрлах газар /хувцас солих өрөө, бие засах, усанд орох, хувцас угаалга, хоолны газар болон амрах байр/-ыг аюултай бүсийн гадна байрлуулах, ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, ил задгай газар ажилтнуудад зориулсан хур тунадаснаас хамгаалах хорго буюу саравчийг барих, үйлдвэрлэлийн талбай, хэсэг, байранд ажилтнуудад эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах, ажилтны хоолны газарт эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнсээр үйлчлэх, хоолны дээж авч, бүртгэл хөтөлдөг эсэхэд хяналт тавьж ажиллах;

15. Үйлдвэрлэлийн талбай хэсэг байр, зам талбай орц, гарцыг шөнийн цагт гэрэлтүүлэх, гэрэлтүүлэггүй газар ажил гүйцэтгүүлэхгүй байх;

16. Ажилтнуудыг гамшигаас хамгаалах сургалтад хамруулан, гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгах;

17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулж ажиллах;

18. Үйлдвэрлэлийн орчныг сайжруулах, хаалт хамгаалалт, анхааруулах дохио санамж, замын орц, гарц, тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлөөр хангах, туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа компаниудын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар захиалагч компанийн зүгээс хяналт тавих, зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллах;

19. Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулах;

Энэхүү албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч бүр хэрэгжүүлэн, биелэлтийг үйл ажиллагаа эрхэлж буй нутаг дэвсгэрт хамаарах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэн, орон нутгийн зөвлөл нь албан даалгаврын биелэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, шийдвэр гаргаж ажиллахыг даалгаж байна.

САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Б.НАРАНГАРАВ